

МОНГОЛ УЛС

Болон

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ)

хоорондын

САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨРТ ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2019-2020 ОНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Монгол Улсын Улаанбаатар хотноо Монгол Улс, АХБ 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр ("Ерөнхий хөтөлбөр")-ийг байгуулсан. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр соёрхон батлагдаж, хууль болсон.
2. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратеги (2017-2020), Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021) болон Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2020-2021)-ний дагуу үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын хүсэлтээр болон АХБ-тай зөвшилцсөний үндсэн дээр Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулахаар тохиров.

(а) Удиртгал (А)-г дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

"(А) Монгол Улс Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратеги (2017-2020), Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021), болон Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2020-2021)-ний дагуу 2019-2020 онд хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор АХБ-аас зээлийн санхүүжилт хүсч болно."

(б) Нэгдүгээр зүйлийн Хэсэг 1.01 (б)-г дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

"(б) 2020 онд зуун далан сая ам.доллар (170,000,000 ам.доллар)¹-ыг АХБ-ны энгийн эх үүсвэрийн сангийн энгийн болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно."

(в) Нэгдүгээр зүйлийн Хэсэг 1.02-г дараах байдлаар өөрчлөв. Үүнд:

"Хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн ерөнхий мэдээлэл Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021) болон Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2020-2021)-нд туссан болно. Монгол Улс өөрийн нутаг дэвсгэр дээр гарах нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөх хэлбэрээр санхүүжилт гаргаж болно."

¹ АХБ-аас 2020 онд Монгол Улсад зуун сая ам.доллар (100,000,000 ам.доллар)-ыг Монгол Улсаас тавьсан хүсэлтийн дагуу эрчим хүчний чиглэлийн хөгжлийн төслийг санхүүжүүлэх зорилгоор нэмэлтээр алгохоор болсон.

3. Дээр дурдсан заалтуудаас бусад тохиолдолд Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр хэвээр үлдэнэ.
4. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт өөрчлөлт нь Монгол Улсын Их Хурал соёрхон баталсан өдрөөр хүчин төгөлдөр болж, Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр хүчин төгөлдөр байх хугацаанд мөн хүчин төгөлдөр байна.
5. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт өөрчлөлт нь Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн салшгүй хэсэг байх ба Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөртэй ижил хууль зүйн хүчин чадалтай байна.

—Заалтуудын төгсгөл—

Монгол Улс, АХБ хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.

Хөтөлбөрийг [2019] оны ... дугаар сарын-ны өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр ижил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ төлөөлж

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКЫГ төлөөлж

.....
САНГИЙН САЙД

.....
МОНГОЛ УЛСЫГ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

